



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/286

Улаанбаатар хот

Журам, загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны “Төрийн үйлчилгээний цахим системийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 254 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны “Боловсролын баримт бичгийн лавалгааг цахим хэлбэрээр олгох тухай” 347 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургууль, дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн баримт бичгийн тодорхойлолтыг Төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машинаас олгох журмыг нэгдүгээр, суурь боловсролын гэрчилгээний тодорхойлолт олгох загварыг хоёрдугаар, бүрэн дунд боловсролын үнэмлэхний тодорхойлолт олгох загварыг гуравдугаар, дээд боловсролын сургалтын байгууллагын дипломын тодорхойлолт олгох загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Төгсөгчдийн баримт бичгийн мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн системд цахим хэлбэрээр үе шаттайгаар бүрэн оруулах ажлыг шуурхай зохион байгуулахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Дээд боловсролын бодлогын газар /Т.Амаржаргалан/, Төрийн захиргааны удирдлагын газар /С.Мөнхөөлэй/-т тус тус үүрэг болгосугай.

3. Боловсролын салбарын мэдээллийн системээс “Хур систем”-тэй холбогдох сервис үүсгэх, холбогдох журмын дагуу Үндэсний дата төв улсын үйлдвэрийн газартай гэрээ байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /С.Мөнхөөлэй/-т, Боловсролын баримт бичгийн тодорхойлолтыг төрийн үйлчилгээний цахим машинаас олгох журамын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /З.Энхболд/-т тус тус даалгасугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

000953

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2018 оны 05-р сарын 14-ний өдрийн
№286 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



БОЛОВСРОЛЫН БАРИМТ БИЧГИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМ МАШИНААС ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Суурь боловсролын гэрчилгээ, бүрэн дунд боловсролын үнэмлэх, дээд боловсролын диплом /цаашид “боловсролын баримт бичиг”/-ын мэдээллийг цахим хэлбэрт оруулах, иргэний хүсэлтээр боловсролын баримт бичгийн тодорхойлолтыг цахим хэлбэрээр олгоход энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Боловсролын баримт бичгийн мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийн хадгалалт, хамгаалалт болон цахим хэлбэрээр баримт бичгийн тодорхойлолт олгох үйл ажиллагааны аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангахад Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 159 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ыг баримтална.

Хоёр. Боловсролын баримт бичгийн цахим
мэдээллийн сан бүрдүүлэх

2.1. Боловсролын баримт бичгийн мэдээллийн санг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистик, мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж бүрдүүлнэ.

2.2. Ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургууль төгсөгчдөд олгосон боловсролын баримт бичгийн мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн систем /цаашид “мэдээллийн систем” гэх/-д цаг хугацааны хоцрогдолгүй бүртгэх үйл ажиллагааг тухайн сургалтын байгууллага хариуцна.

2.3. Мэдээллийн системд сургалтын байгууллагаас бүртгэгдсэн боловсролын баримт бичгийн үнэн зөв, бодит байдалд аймаг, нийслэлийн боловсролын газар, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистик, мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж тус тус хянаж баталгаажуулалт хийнэ.

2.4. Боловсролын баримт бичиг/гэрчилгээ, үнэмлэх/-ийг иргэнд дахин олгосон тохиолдолд шинээр олгосон баримт бичгийн дугаарыг энэхүү журмын 2.2-д заасан байгууллага тухай бүр мэдээллийн системд бүртгэж, дахин олгосон шалтгааныг бичнэ.

2.5. 2018 оноос өмнө олгогдсон боловсролын баримт бичгийг архивын ерөнхий газар болон сургалтын байгууллагын архивын мэдээлэл, статистикийн мэдээлэлд тус тус үндэслэн мэдээллийн системд Боловсролын асуудал эрхэлсэн төрийн

10 хичээл нэмж

захиргааны төв байгууллагын статистик, мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж хянасны үндсэн дээр оруулна. Хэрэв өмнөх онуудад олгогдсон боловсролын баримт бичгийн дугаар давхардсан тохиолдолд аль нэг байгууллагын мэдээллийн ард “ * ” тэмдэглэл хийж оруулна.

2.6. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистик, мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгжийн хянаж баталгаажуулсан боловсролын баримт бичгийн мэдээллийг төрийн үйлчилгээний цахим машин /цаашид “ТҮЦ машин” гэх/-ны “Боловсролын баримт бичиг” үйлчилгээ хэсэгт байршуулна.

2.7. Боловсролын баримт бичгийн тодорхойлолттой холбогдох мэдээлэл солилцооны техникийн асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, “Үндэсний дата төв” Улсын төсөвт үйлдвэрийн газартай байгуулсан гэрээгээр зохицуулна.

2.8. Боловсролын баримт бичгийн мэдээллийг ТҮЦ машины системд автоматаар олгох, цаг хугацааны хоцрогдолгүй шинэчлэх, цахим мэдээлэл солилцох сервис үүсгэх ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистик, мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж хийнэ.

2.9. Мэдээллийн системд боловсролын баримт бичгийн мэдээллийг хугацааны хоцрогдолгүй бүртгэх, өөрчлөлт орсон тохиолдол бүрт ТҮЦ машины системийн мэдээлэл автоматаар шинэчлэгдэх бөгөөд энэхүү үйл ажиллагаанд Үндэсний дата төв улсын үйлдвэрийн газрын “ХУР” төрийн мэдээлэл солилцооны системийг ашиглана.

Гурав. Боловсролын баримт бичгийн тодорхойлолт үйлдэх

3.1. Боловсролын баримт бичгийн тодорхойлолтыг иргэнд Төрийн үйлчилгээний цахим машинаар олгоно.

3.2. Боловсролын баримт бичгийн тодорхойлолт олгох үйлчилгээний хөлсийг Архивын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

3.3. Боловсролын баримт бичгийн лавлагаа, тодорхойлолт нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан ёсны баримт бичиг болохын хувьд улсын хэмжээнд мөрдөгдөж, аливаа байгууллага, хуулийн этгээд, хувь хүний өмнө хүчин төгөлдөр байна.

3.4. ТҮЦ машинаас олгож байгаа лавлагаа, тодорхойлолт нь бар код, тэмдэгтээр баталгаажина. Лавлагаа, тодорхойлолт нь 45 хоног хүчинтэй байна.

3.5. Мэдээллийн сангийн програм хангамж, техник технологи, мэдээллийн аюулгүй байдал болон нууцлалын асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистик, мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж хяналт тавьж ажиллана.

3.6. Боловсролын баримт бичгийн лавлагаа, тодорхойлолтын мэдээлэл зөрүүтэй гарснаас үүсэх хариуцлагыг аймаг, нийслэлийн боловсрол, соёл урлагийн газар, дүүргийн боловсролын хэлтэс, их, дээд сургуулийн сургалтын албаны дарга болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистик, мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж тус тус хүлээнэ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2018 оны 05-р сарын 14-ний өдрийн
1/2886 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМ МАШИНААС
СУУРЬ БОЛОВСРОЛЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ
ТОДОРХОЙЛОЛТ ОЛГОХ ЗАГВАР**

**СУУРЬ БОЛОВСРОЛЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ
ТОДОРХОЙЛОЛТ**

Монгол Улсын иргэн регистрийн дугаартай
. овогтой нь /аймаг, нийслэл/-
ийн ерөнхий боловсролын
. . . . сургуулийг онд БГ. дугаар бүхий "Суурь
боловсролын гэрчилгээ"-тэй төгссөн болно.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

Тодорхойлолтын хүчинтэй хугацаа 45 хоног

Энэхүү тодорхойлолтын хүчинтэй эсэхийг
<http://tutsmashin.gov.mn> болон <http://esis.edu.mn> –ээс шалгах боломжтой

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2018 оны 05-р сарын 14-ний өдрийн
А/286 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМ МАШИНААС
БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ҮНЭМЛЭХНИЙ
ТОДОРХОЙЛОЛТ ОЛГОХ ЗАГВАР**

**БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ҮНЭМЛЭХНИЙ
ТОДОРХОЙЛОЛТ**

Монгол Улсын иргэн регистрийн дугаартай
. овогтой нь /аймаг, нийслэл/
ийн ерөнхий боловсролын
. . . сургуулийг онд БҮ. дугаар бүхий “Бүрэн дунд
боловсролын үнэмлэх”-тэй төгссөн болно.

Энэхүү үнэмлэх нь Монгол Улсын иргэнийг бүрэн дунд боловсрол эзэмшсэн болохыг
гэрчилсэн боловсролын баримт бичиг бөгөөд БҮ. дугаар бүхий тус
үнэмлэх нь дараа шатны дотоод, гадаадын их, дээд сургууль, коллежид
үргэлжлүүлэн суралцахад хүчин төгөлдөр баримт бичиг болно.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

Тодорхойлолтын хүчинтэй хугацаа 45 хоног

Энэхүү тодорхойлолтын хүчинтэй эсэхийг
<http://tutsmashin.gov.mn> болон <http://esis.edu.mn> –ээс шалгах боломжтой

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2018 оны 05-р сарын 14-ний өдрийн
дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМ МАШИНААС
ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
ДИПЛОМЫН ТОДОРХОЙЛОЛТ ОЛГОХ ЗАГВАР**

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
ДИПЛОМЫН ТОДОРХОЙЛОЛТ**

Монгол Улсын иргэн регистрийн дугаартай
овогтой нь
.....
сургуулийг онд индекстэй
..... мэргэжлээр/хөтөлбөрөөр
..... зэрэгтэйгээр бүртгэлийн
дугаартай, бүхий дугаарын дипломтой төгссөн болно.

Тус тодорхойлолтыг дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөлтийн мэдээллийн санд мэдээллэлд үндэслэв.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

Тодорхойлолтын хүчинтэй хугацаа 45 хоног

Энэхүү тодорхойлолтын хүчинтэй эсэхийг
<http://tutsmashin.gov.mn> болон <http://esis.edu.mn> –ээс шалгах боломжтой